



Аудитын код: САГ-2017/16/СТА-ТЕЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу:

Цахим хуудас: www.audit.mn

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг

Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер Г.Гүнжидмаа

Утас: 261628 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn

Аудитор П.Чанцалдулам

Утас: 261885 Цахим хаяг: chantsaldulamp@audit.gov.mn

Улаанбаатар хот

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	2
1.1	Оршил	4
1.2	Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл	4
1.3	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
1.4	Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	6
1.5	Дотоод хяналт	7
1.6	Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар	8
1.7	Шилэн дансны мэдээлэл	9
1.8	Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар	9
1.9	Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл	10
1.9.1	Санхүүгийн тайлан гаргалтын талаар	10
1.9.2	Төсвийн шууд захирагч нарын 2016 оны санхүүгийн тайланд хийгдсэн аудитаар хөндөгдсөн гол асуудлууд	11
1.9.3	Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:	12
1.10	Анхаарал татахуйц бусад чухал асуудал	13
1.11	Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд	14
1.12	Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл	14
1.13	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
1.14	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар:	14
1.15	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	14
2	Менежментийн захидал	15
2.1	Үндсэн хөрөнгийн талаар	16
2.2	Цалин орон тооны талаар	17
2.3	Дотоод хяналтын талаар	18
3	Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл	19
3.1	Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	19
3.2	Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	20
3.3	Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	21
3.4	Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан	22
3.5	Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	23

1 Аудитын гэрчилгээ



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26 04 37, Факс: (976) 6226 3230,
E-mail: info@audit.gov.mn, http://www.audit.mn

2017. 04. 25 № 746
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Монгол Улсын Ерөнхий прокурорын төсвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Монгол Улсын Ерөнхий прокурор нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн нэгтгэсэн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангууд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан "Санхүүгийн тайлангийн аудитын журам"-ын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журмын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.

Аудитаар санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, тэдгээрийг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгаж, удирдлагын хийсэн томоохон тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлсэн.


Бидний хийсэн аудит санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Монгол Улсын Ерөнхий прокурорын төсвийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

Зөрчилгүй санал дүгнэлт

Монгол Улсын Ерөнхий прокурорын төсвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, шударга илэрхийлсэн байна.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



Д.ХҮРЭЛБААТАР

1.1 Оршил

Монгол Улсын Ерөнхий прокурорын төсвийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайланг Монгол Улсын Ерөнхий прокурор М.Энх-Амгалан танд танилцуулж байна.

Энэхүү тайланд танай санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан “Санхүүгийн тайлангийн аудитын журам”, гарын авлагад дурьдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын системд оруулсан бөгөөд аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

1.2 Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-т заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд энэ хуулийн 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5 дахь заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Ерөнхий прокурорын төсвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл, УАГ-2017/16/СТА-ТЕЗ-д санхүүгийн тайлангийн аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэв.

Монгол Улсын Ерөнхий прокурорын төсвийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн

зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Монгол Улсын Ерөнхий прокурорын төсвийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитыг 2017 оны 4 дүгээр сарын 6-наас 2017 оны 4 дүгээр сарын 14-ны хооронд хийхээр төлөвлөн Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын аудитор П.Чанцалдулам хэрэгжүүлэв.

Монгол Улсын Ерөнхий прокурорын төсвийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг 2017 оны 4 дүгээр сарын 5-ны өдрийн 2/1378 дугаар албан бичгээр Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна.

Үндэсний аудитын газар аудитыг 2017 оны 4 дүгээр сарын 6-наас 2017 оны 4 дүгээр сарын 14-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2017 оны 4 дүгээр сарын 25-нд Монгол Улсын Ерөнхий прокурорт гардуулна.

1.3 БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Прокурорын байгууллага нь Монгол Улсын нутаг дэвсгэрт эрүүгийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг нэг мөр хангуулах үндсэн чиг үүрэг бүхий, үйл ажиллагаагаа төрийн нэрийн өмнөөс явуулдаг, бие даасан, хараат бус, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд оролцогч байгууллага болно.

Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд хүний эрхийг баталгаатай хангах явдлыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон хэвшүүлэх, шударга ёс, тэгш байдлыг хангах, прокурорын ёс зүйг чандлан сахиж, мэргэжлийн өндөр ур чадвар, хууль дээдлэх зарчимд түшиглэсэн хууль сахиулах шударга тогтолцоог бий болгох нь Прокурорын байгууллагын зорилт юм.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д “Дараах албан тушаалтан төсвийн ерөнхийлөн захирагч байна” мөн хуулийн 14.1.12-т “Улсын ерөнхий прокурор прокурорын байгууллагын төсвийн” гэж заасны дагуу Улсын ерөнхий прокурор нь Төсвийн ерөнхийлөн захирагчийн үүргийг гүйцэтгэж байна.

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3-т “Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын төсвийн орлого, зарлагын зүй зохистой, үр ашигтай байдал, үр дүнгийн гүйцэтгэлийг хангаж, өөрт хамаарах төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн шатны Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засгийн газар, Улсын Их Хурлын өмнө бүрэн хариуцна”, мөн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д “Төсвийн ерөнхийлөн захирагч хагас жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланг жил бүрийн 8 дугаар сарын 15-ны дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланг дараа оны 4 дүгээр сарын 5-ны дотор Төрийн аудитын төв байгууллагад хүргүүлж, аудит хийсэн тайланг жил бүрийн 4 дүгээр сарын 25-ны дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх” гэж заасныг тус тус баримтлан тайлагнасан байна.

Тухайн байгууллагын 2016 оны төсвийн санхүүжилтийг Сангийн яамны төрийн сангаас олгосон байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Монгол Улсын Төсвийн тухай хууль болон бусад холбогдох хуулиуд, Улсын секторын

нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, Сангийн сайдын 2006 оны 388, 2008 оны 352 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, санхүүгийн тайлан, тодруулгын маягт, санхүүгийн тайлан бэлтгэж гаргах аргачлал, “Эдийн засгийн ангилал батлах тухай” Сангийн сайдын 2014 оны 5 дугаар тушаалаар баталсан Төсвийн эх үүсвэрийн ангилал, Төсвийн бусад мэдээллийн болон Балансын дансны ангилал, “Тушаалд өөрчлөлт оруулах тухай” 2014 оны 55 дугаар тушаалаар Төсвийн зарлагын эдийн засгийн ангиллыг ашиглах заавар, “Төсвийн ангилал шинэчлэн батлах тухай” 2015 оны 7 дугаар тушаалаар баталсан “Төсвийн орлогын эдийн засгийн ангилал, Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал, Төсвийн зарлагын хөтөлбөрийн ангилал, Зардлын зориулалт, арга хэмжээний ангилал”, “Журам шинэчлэн батлах тухай” 2015 оны “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ыг 1 дүгээр хавсралт, “Санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгын маягт”-ыг 2 дугаар хавсралтаар 341 дүгээр тушаалаар баталсан эрх зүйн актуудыг тус бүр мөрдөн ашиглаж байна.

Түүнчлэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогтой холбоотой холбогдох бусад хууль тогтоомжууд, тэдгээрийн хэрэгжилтийг хангуулахаар гаргасан Засгийн газрын тогтоол, Сангийн сайдын тушаал, Монгол Улсын Ерөнхий прокурорын тушаалаар баталсан дүрэм, журам, заавар, аргачлалыг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Аудитын явцад төсвийн ерөнхийлөн захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг Улсын ерөнхий прокурорын газар болон харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд хэрэгжүүлэн ажиллаж байна.

1.4 Аудитын шалгуур үзүүлэлт, АРГА ЗҮЙ, ХЭРЭГЖҮҮЛСЭН ГОРИМ СОРИЛ, ТҮҮНИЙ ҮР ДҮН

Аудит хийхэд Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000 – 1810 буюу Санхүүгийн аудитын удирдамж, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

Тайлант онд Монгол Улсын Ерөнхий прокурорын 2016 оны А/28 дугаар тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж ажилласан байна.

Монгол Улсын Ерөнхий прокурорын төсвийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан, түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд “дунд” буюу мэдээллийн технологийн мэргэжилтний оролцоо шаардагдах магадлалтай гэсэн үнэлгээ гарсан. /ТАБ-СТА-В-2/

Тайлант хугацаанд Улсын ерөнхий прокурорын газрын харьяа прокурорын байгууллагууд нь “Acoulous 3.0” програмаар хөтөлж, санхүүгийн тайланг гаргаж, тайлагнажээ. Харин системийн санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн яамны “Э-тайлан” програмаар нэгтгэн гаргасан байна.

Аудитаар Монгол Улсын Ерөнхий прокурорын төсвийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсөв захирагчийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Гүйцэтгэлийн шатанд санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансдад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорил 9-г гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Аудитын нарийвчилсан горим, сорилыг хэрэгжүүлэх явцад гарсан зарим онцлог ажил гүйлгээнээс дурдвал дараах байдалтай байна.

Тайлант онд нэмэлт төсвийн харилцах дансанд засаг даргын нөөц хөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 143.7 сая, төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 16.7 сая, нийт 160.4 сая төгрөгийн орлогыг бүртгэж, тогтмол зардалд 5.1 сая, хангамжийн бараа материалын зардалд 5.7 сая, эд хогшил урсгал засварын зардалд 35.9 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжид 0.6 сая, бараа үйлчилгээний бусад зардалд 85.4 сая, урсгал шилжүүлэгт 0.8 сая, хөрөнгийн зардалд 23.0 сая, нийт 156.5 сая төгрөгийн зарлагын ажил гүйлгээг хийж, 2016 оны жилийн эцэст 3.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан байна.

1.5 Дотоод хяналт

Бид санхүүгийн нэгтгэсэн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Монгол Улсын Ерөнхий прокурорын 2015 оны А/22 дугаар тушаалаар тус байгууллагын бүтэц, орон тоог баталж, Дотоод аюулгүй байдлын хэлтсийг 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж, УЕП-ын туслах, хэлтсийн дарга-1, хяналтын прокурор-4, дотоод аудитор-1 гэсэн орон тоотойгоор ажил үүргээ гүйцэтгэж иржээ.

Дотоод аюулгүй байдлын хэлтэс нь улирал бүр ажлын төлөвлөгөө гарган батлуулж ажилладаг бөгөөд дотоод аудитор нь харьяа прокурорын байгууллагуудын хөрөнгийн хөдөлгөөн, бэлэн мөнгөний зарлагын гүйлгээнд хяналт тавьж, ажлаа Улсын ерөнхий прокурор болон түүний дэргэдэх зөвлөлийн хуралд тайлагнадаг байна.

УЕП-ын Тамгын газрын даргын 2016 оны А/15 дугаар тушаалаар “Өмч хамгаалах байнгын зөвлөл”-ийг шинэчлэн 7 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж, хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, гадаад шилжилт хөдөлгөөн, хөрөнгө акталж устгах, худалдан борлуулах, үнэлгээ тогтоох, хөрөнгийн тооллогын дүнг хэлэлцэж шийдвэр, дүгнэлт гаргах үүрэгтэй ажилладаг байна.

Тус байгууллагын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үед дунд гэж тооцсон ба дахин хянахад ТШЗ-ийн хэмжээнд аудитаар илэрсэн асуудлуудад анхаарал хандуулж, давтан гаргахгүй байхад дотоод хяналтыг чиглүүлэн ажиллах шаардлагатай байна.

Дотоод аюулгүй байдлын хэлтсийн 2016 онд хийх ажлын төлөвлөгөөг Монгол Улсын Ерөнхий прокуророор батлуулан төлөвлөгөөнд тусгагдсан дараах ажлыг хийж гүйцэтгэсэн байна. Үүнд:

- Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор Шилэн дансны тайлан, мэдээг нэгж тус бүрээр prokuror.mn, shilendans.gov.mn сайтад сар бүр мэдээллийг байршуулж хэвшүүлсэн ба шилэн дансны тайланг сар бүр хугацаанд нь үнэн зөв бүртгэсэн эсэхэд хяналт тавьж, шилэн дансны тайлан, мэдээллийг сар, улирал, хагас, бүтэн жилээр авч, нэгтгэн холбогдох газруудад хүргүүлэн ажилласан;
- Нийслэлийн Налайх дүүргийн Прокурорын газрын санхүүгийн тайланд 85.6 сая төгрөгийн зөрчил илрүүлж, залруулга гүйлгээ хийлгэж, зөвлөмж хүргүүлсэн;
- 2015 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн дагуу харьяа газар нэгжүүдийн аудитын тайлангаар илэрсэн алдаа зөрчлүүдийг нэгтгэн судалж, Ерөнхий прокурор болон Тамгын газарт танилцуулан гаргасан алдаа зөрчлүүдийг дахин давтахгүй байхад анхаарч, газар нэгжүүдийн Тамгын газрын дарга, нягтлан бодогч нарт зөвлөмж хүргүүлэн, холбогдох байгууллагуудын мэргэжилтнүүдтэй хамтран видео хичээл зохион байгуулсан;

Дотоод аюулгүй байдлын хэлтсийн дотоод аудитор 2016 оны 6 сард ажлаасаа чөлөөлөгдөж, тухайн орон тоон дээр өнөөг хүртэл ажилтан томилогдоогүй, УЕП-ын системийн хэмжээнд 41 байгууллага нэгтгэгддэг боловч зөвхөн Нийслэлийн Налайх дүүргийн прокурорын газрын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудитын шалгалт хийсэн нь хангалтгүй байна.

1.6 Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар

Улсын Ерөнхий прокурорын газрын системийн хэмжээнд 2016 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу харьяа газар, нэгжүүдэд Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулан, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангаж, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавьж ажилласан байна.

Мөнгөн хөрөнгийн дансны эхний үлдэгдэл 589.1 сая төгрөг, тайлант онд улсын төсвийн урсгал санхүүжилтээс 16,171.9 сая, төвлөрүүлэх шилжүүлгээс 0.4 сая, хөрөнгө оруулалтын санхүүжилтээс 1,488.2 сая, нэмэлт санхүүжилтээс 160.4 сая, нийгмийн даатгалын орлогоос 29.8 сая, барьцаа хөрөнгийн орлогоос 148.4 сая, туслах үйл ажиллагааны орлогоос 3.9 сая, ханшийн зөрүүний олз 0.9 сая төгрөгийн эх үүсвэрийг тус тус орлогоор бүртгэж, барьцаа хөрөнгийн шилжүүлэгт 419.2 сая, төвлөрүүлэх шилжүүлэгт 9.8 сая, нийгмийн даатгал болон халамжийн тэтгэвэр тэтгэмжид 29.8 сая, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжид 194.0 сая, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулалд 85.9 сая, үйл ажиллагааны зардалд 16,054.1 сая, хөрөнгийн зардалд 1,545.9 сая төгрөгийг тус тус зарцуулж, мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 254.3 сая төгрөг байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016 оны батлагдсан төсөв 17,660.2 сая төгрөг, тайлант онд гүйцэтгэлээр нийт 17,652.4 сая төгрөгийг зарцуулж, 7.8 сая төгрөг зарцуулагдаагүй байна.

Сангийн сайдын 2014 оны 5, 2015 оны 7, 2013 оны 73 дугаар тушаалын дагуу бараа үйлчилгээний зардлын бүлэг хооронд зохицуулалт хийгдсэн боловч зардлын ангиллаар авч үзвэл цалин 76.2 сая, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 0.7 сая, гэрэл цахилгаан 17.0 сая, бичиг хэрэг 3.2 сая, ном хэвлэл 0.4 сая, БҮТЭЗ 7.0 сая, эд хогшил, урсгал засварын зардал 1.0 сая, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардал 0.4 сая төгрөгөөр тус бүр хэтэрсэн үзүүлэлттэй байна.

Хөрөнгө оруулалтын зардалд 1,488.3 сая төгрөг батлагдсанаас 1,488.1 сая төгрөгийг санхүүжүүлж, зарцуулагдаагүй үлдэгдэл 0.2 сая төгрөг байна.

Хөрөнгө оруулалтын санхүүжилтийн 43.2 хувь буюу 643.0 сая төгрөг нь өмнөх онд Сангийн яамтай хийсэн тооцоогоор өглөгт бүртгэсэн векселиэрх төлбөрийн санхүүжилт мөн Баян-Өлгий аймгийн прокурор, Өмнөговь аймгийн Ханбогд сум дахь сум дундын прокурорын газрын барилгын санхүүжилтийн үлдэгдэл төлбөр 845.1 сая төгрөг, нийт 1,488.1 сая төгрөгийн санхүүжилтийг тус тус тайлант онд олгож, өмнөх оны өглөгийн үлдэгдлийг барагдуулсан байна.

1.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн дагуу төсвийн болон улс, орон нутгийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирдлагын шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоог хуулийн дагуу хангасан эсэх, хуулийн хэрэгжилтийн явцтай танилцахад:

Шилэн данс хуудсанд төсвийн ерөнхийлөн захирагчийн тухайн жилийн төсөв, гүйцэтгэл, төсөвт орсон нэмэлт өөрчлөлт, хагас жилийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн хэмнэлт, хэтрэлтийн тайлбар, хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, концессийн зүйлийн жагсаалт, бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр 12-г мэдээлэхээс 9-г мэдээлсэн, Худалдан авах ажиллагааны 2016 оны хэрэгжилтэд өгсөн үнэлгээний тайлан, 5 сая төгрөгөөс дээших 4 гүйлгээний нотлох баримт зэрэг мэдээллийг байршуулж, УЕП-ын системийн хэмжээнд мэдээлэх ёстой нийт 6,258 мэдээллээс 6,240 мэдээллийг нийтэд нээлттэй мэдээлж, хэрэгжилт нь 99.7 хувьтай тайланг Сангийн яаманд хүргүүлсэн байна.

1.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 11 эрсдэлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 9 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнг гүйцэтгэлийн үе шатны “Төлөвлөсөн горим, сорилуудыг хэрэгжүүлж, үр дүнг аудитын чиглэл тус бүрээр баримтжуулах” гэсэн үе шатны ажилд хамааруулан ТАБ-СТА-В-3 маягтаар данс тус бүрээр баримтжуулсан болно.

Монгол Улсын Ерөнхий прокурорын төсвийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний дүн бүхий дансдын ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

- УЕП-ын системийн хэмжээнд тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан бэлтгэсэн үндсэн хөрөнгийг 57.7 сая төгрөгөөр бүртгэж, тайлагнасан байна. Үүнээс Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хуульд тусгагдсан урсгал төсвөөс 9.7 сая, Нийслэл болон орон нутгийн Засаг даргын нөөц хөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгийн эх үүсвэрээс 48.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг тус тус бэлтгэжээ.

- Нийслэл болон орон нутгийн Засаг даргын нөөц хөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгийн эх үүсвэрээс Өвөрхангай аймгийн Хархорин сум дахь сум дундын прокурорын газар 20.0 сая, Тээврийн прокурорын газар 23.0 сая төгрөгөөр тус тус автомашин худалдан авсан байна.
- ЗГ-ын 2015 оны 184 дүгээр тогтоолын 8-д “төсвөөс санхүүждэг байгууллага хот дотор ажил үйлчилгээнд хөдөлгүүрийн цилиндрийн багтаамж нь 2500 см³-ээс дээш, туулах чадвар өндөртэй, шатахуун их зарцуулдаг автомашин хэрэглэхийг хориглоно” гэсэн заалттай нийцэхгүй 3498-5700 см³ хөдөлгүүрийн багтаамжтай нийт 7 автомашин УЕП-ын Тамгын газарт ашиглагдаж байна.

1.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

Аудитын явцад Улсын ерөнхий прокурорын газрын системийн хэмжээнд мөрдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлого, нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэж гаргах аргачлалын дагуу ажил гүйлгээг бүртгэлд тусгасан байдал, дансны болон устгах бичилтийг арга зүйн хувьд нягтлан үзэж санхүүгийн тайлангийн илэрхийлэлд үнэлэлт өгсөн.

1.9.1 Санхүүгийн тайлан гаргалтын талаар

Монгол Улсын Ерөнхий прокурорын төсвийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг УСНББОУС-6, Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан журам дахь заалтын дагуу мөр бүрээр нэгтгэх зарчмыг баримтлан ТШЗ-ийн аудит хийсэн санхүүгийн тайланг нэгтгэн толилуулсан байна.

Монгол Улсын Ерөнхий прокурорын төсвийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нийт 41 ТШЗ-ын санхүүгийн тайлан нэгтгэгдсэн бөгөөд нийт төсвийн 25.8 хувьд Үндэсний аудитын газар, 31.4 хувьд Нийслэл дэх Төрийн аудитын газар, 30.3 хувьд аймаг, орон нутаг дахь Төрийн аудитын газар, 2.3 хувьд нь хараат бус аудитын компани аудит хийж, 10.2 хувь буюу Баян-Өлгий, Баянхонгор, Өмнөговь, Сүхбаатар, Увс, Хөвсгөл аймгуудын прокурорын газруудад, Сэлэнгэ аймгийн Сайхан сум дахь сум дундын прокурор, Хэнтий аймгийн Бор-Өндөр сум дахь сум дундын прокурорын газарт итгэл үзүүлж, Эрүүгийн хэргийн төв архив болон бусад холбогдох данс түүврээр хамрагдсан байна.

2016 оны ТШЗ-дын санхүүгийн тайлангийн аудитаар аудит хийгдсэн бүх прокурорын газруудад “зөрчилгүй” санал дүгнэлтийг өгсөн байна.

Авлага, өглөгийн дансны талаар:

УЕП-ын газраас авсан судалгаагаар тус байгууллагын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд тайлагнагдсан авлагын үлдэгдэл 31.3 сая, өглөгийн үлдэгдэл 476.1 сая төгрөг ба өмнөх оны мөн үеэс авлага 28.2 хувь буюу 12.3 сая төгрөгөөр буурч, өглөг 76.6 хувь буюу 1,559.8 сая төгрөгөөр буурсан байна. Нийт авлагын үлдэгдлийн 81.1 хувь буюу 25.4 сая, өглөгийн үлдэгдлийн 99.8 хувь буюу 475.2 сая төгрөгийг тус тус тооцоо нийлж баталгаажуулсан байна.

Авлагыг насжилтаар нь авч үзвэл 0.8 сая төгрөгийн авлага нь 4-өөс дээш жил болсон мөн 0.3 сая төгрөгийн найдваргүй авлагад тооцогдох эзэн холбогдогч тодорхойгүй авлага бүртгэлтэй байна.

Авлага, өглөгийн судалгаагаар нийт авлагын үлдэгдлийн 26.8 хувь буюу 8.4 сая төгрөг нь Улсын ерөнхий прокурорын Тамгын газар, 24.0 хувь буюу 7.5 сая төгрөг нь Сонгинохайрхан, Баянгол дүүрэг, 30.3 хувь буюу 9.5 сая төгрөг нь Дорноговь, Сэлэнгэ аймгийн Зүүнхараа сум дахь сум дундын прокурорын газруудын авлагын үлдэгдэл

байна. Дээрх байгууллагуудын авлагын үлдэгдэл болох 25.4 сая төгрөгийн 60.2 хувь буюу 15.3 сая төгрөг нь татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн авлага, 36.2 хувь буюу 9.2 сая төгрөг нь гэрэл цахилгаан, цалин, байгууллагаас авах авлага байна.

Нийт өглөгийн үлдэгдлийн 44.7 хувь буюу 212.8 сая төгрөг нь УЕП-ын Тамгын газар, 38.1 хувь буюу 181.6 сая төгрөг нь Нийслэл, Хан-Уул, Сүхбаатар, Чингэлтэй Баянгол, Налайх дүүргийн прокурорын газар, 6 хувь буюу 28.8 сая төгрөг нь Төв, Булган аймгуудын прокурорын газруудын өглөгийн үлдэгдэл байна.

Өглөг 1,559.8 сая төгрөгөөр буурсан нь өмнөх онд Сангийн яамтай хийсэн тооцоогоор өглөгт бүртгэсэн векселиэрх төлбөр болох тоног төхөөрөмж 159.0 сая, албан хаагчдын барилга 250.0 сая, Сэлэнгэ аймгийн прокурорын барилгын санхүүжилт 234.0 сая төгрөгийн үлдэгдлийг тус бүр барагдуулсантай холбоотой мөн Баян-Өлгий, Өмнөговь аймгийн Ханбогд сум дахь сум дундын прокурорын барилгын үлдэгдэл 837.8 сая төгрөгийг төлсөн нь голлон нөлөөлсөн байна. Нийт өглөгийн үлдэгдлийн 35.1 хувь буюу 167.0 сая төгрөг нь барьцаа хөрөнгийн өглөг байна.

1.9.2 Төсвийн шууд захирагч нарын 2016 оны санхүүгийн тайланд хийгдсэн аудитаар хөндөгдсөн гол асуудлууд

Төсвийн шууд захирагчдын 2015 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 1,983.3 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрч байсан бол тайлант онд нийт 1,123.8 сая төгрөгийн алдаа зөрчил илрүүлснээс 0.4 сая төгрөгийн зөрчилд 1 акт тогтоосон, албан шаардлага бичигдээгүй, 257.7 сая төгрөгийн зөрчилд 61 зөвлөмж өгч, 865.7 сая төгрөгийн алдааг залруулсан байна.

2016 онд Төсвийн шууд захирагчдын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 257.7 сая төгрөгийн зөрчилд 61 зөвлөмж өгсний 11 нь бүртгэл, тайлагналтай холбоотой, 48 нь хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой, 2 нь төлөвлөлт, хяналт, дотоод аудитын чанар, үр нөлөөг сайжруулахтай холбоотой байна.

Тээврийн прокурор, Говь-Алтай, Дорнод, Завхан аймгуудын прокурорын газар, Завхан аймгийн Тосонцэнгэл, Өвөрхангай аймгийн Хархорин, Өмнөговь аймгийн Ханбогд сум дахь сум дундын прокурорын газруудад аудит хийсэн боловч менежментийн захидлаар ямар нэгэн зөвлөмж өгөгдөөгүй байна.

Санхүүгийн тайлагнал болон хууль эрх зүйн асуудал

- УЕП-ын харьяа прокурорын газрууд нь 281.9 сая төгрөгийн өглөгтэй тайлагнагдсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д үндэслэн төсвийн сахилга батыг сахиж, урсгал зардлыг бууруулж, шинээр нэмж өр төлбөр үүсгэхгүй байх гэсэнтэй нийцэхгүй байна.
- УЕП-ын тушаалаар Засгийн газрын 2007 оны “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан тушаалын ангилал, зэрэглэлийг шинэчлэн тогтоох тухай” 354 дүгээр тогтоол, Засгийн газрын 2014 оны “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, доод жишгийг шинэчлэн тогтоох тухай” 332 дугаар тогтоолуудыг зөрчин албан тушаалын ангилал, зэрэглэлийг буруу тогтоосноос 35.4 сая төгрөгийг илүү олгосон.
- Дүүргийн прокурорын газруудад гарсан нийтлэг алдаа дутагдал нь 175.5 сая төгрөгийн ажил гүйлгээг урьдчилгаа-цалингийн тооцооны дансаар дамжуулан бүртгээгүй нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын холбогдох заалттай нийцэхгүй байна.

Бараа материал, үндсэн хөрөнгийн бүртгэл, ангиллын талаар

- Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийгдээгүй, бараа материалын дансанд хөрөнгийг нэр төрөл, тоо ширхэгээр бүртгэж тайлагнаагүй, хөрөнгийг буруу

ангилан бүртгэсэн, бараа материалыг холбогдох дансаар нь дамжуулалгүй шууд зардалд бүртгэсэн зэрэг нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан “Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын холбогдох заалтуудтай нийцэхгүй байна.

ТШЗ-ийн хэмжээнд илэрсэн дээрх асуудлууд нь 2015 оны ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар мөн адил хөндөгдсөн тул аудитаар илэрсэн бүх асуудлыг тус байгууллагын удирдлага болон Дотоод аюулгүй байдлын хэлтэс судлан шийдвэрлэх шаардлагатай байгааг Улсын ерөнхий прокурорын газрын удирдлагуудын анхааралд хандуулж байна.

1.9.3 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

1. Тайлант онд түүвэрт хамрагдсан Эрүүгийн хэргийн төв архивын газарт ашиглагдаж байгаа нийт 5.0 сая төгрөгийн анхны өртөгтэй 1.2 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй 4 нэр төрлийн тавилга эд хогшил нь УЕП-ын Тамгын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 3-т “Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр хандивлах, бэлэглэх, барьцаалах, зээлдүүлэх, бусад өмчийн хуулийн этгээдэд хувь хөрөнгө болгон оруулахыг хориглоно”, Иж бүрэн байх батламж мэдэгдлийн “Аж ахуйн нэгж, байгууллага тайлант хугацаанд гарсан бүх ажил гүйлгээ, үлдэгдэл буюу үйл явдал, нөхцөл байдлуудаас бүртгээгүй, нэмж тодруулаагүй, орхигдуулсан зүйлсгүй байх” гэсэнтэй тус бүр нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн заалтыг баримталж, эрх бүхий байгууллагын холбогдох шийдвэрээр хөрөнгийн хөдөлгөөнийг хийж, бүртгэлд тусгаж байхыг УЕП-ын удирдлагад зөвлөмж болгох;

2. Төсвийн шууд захирагчдын 2016 оны санхүүгийн тайлангийн аудитаар гарсан нийтлэг алдааг УЕП-ын газрын удирдлагуудад хандуулбал дараах байдалтай байна.
 - УЕП-ын харьяа прокурорын газрууд нь нийт 175.5 сая төгрөгийн ажил гүйлгээг урьдчилгаа-цалингийн тооцооны дансаар дамжуулан бүртгээгүйгээс аудитаар ажиллагсадтай холбоотой авлага, өглөгийн тооцоо үүссэн;
 - УЕП-ын газрын даргын тушаалаар төрийн үйлчилгээний албан хаагчдын албан тушаалын ангилал, зэрэглэлийг буруу тогтоосноос нийт 35.4 сая төгрөгийг тайлант онд илүү олгосон;

УЕП-ын газраас авсан орон тоо, цалин, НДШ-ийн зардлын судалгаанаас үзэхэд 2016 оны Төсвийн тухай хуулиар баталсан цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл бүлгийн дүнгээр батлагдсан төсвөөс хэтрээгүй боловч батлагдсан орон тооны хязгаарыг хэтрүүлэн нийт 33 гэрээт ажилтанг ажиллуулж, цалин хөлс олгож, холбогдох зардлуудыг төлсөн байна.

Энэ нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”, Засгийн газрын 2007 оны “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан тушаалын ангилал, зэрэглэлийг шинэчлэн тогтоох тухай” 354 дүгээр тогтоол, Засгийн газрын 2014 оны “Төрийн албан

хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, доод жишгийг шинэчлэн тогтоох тухай” 332 дугаар тогтоол, 2016 оны төсвийн тухай хуультай тус бүр нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар", Засгийн газрын 2007 оны 354, 2014 оны 332 дугаар тогтоолтой нийцүүлэн ажиллагсдын цалин хөлсийг зөв тогтоож, тооцоолон санхүүгийн тайланд үнэн зөв тайлагнаж байх, батлагдсан орон тооны хязгаарт багтаан ажиллаж, урсгал төсвийг хэмнэхийг УЕП-ын удирдлагад зөвлөмж болгох;

3. Төсвийн шууд захирагчдын 2015 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 1,983.3 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрч байсан бол тайлант онд нийт 1,123.8 сая төгрөгийн алдаа зөрчил илэрч 0.4 сая төгрөгийн зөрчилд 1 акт тогтоож, 257.7 сая төгрөгийн зөрчилд 61 зөвлөмж өгч, 865.7 сая төгрөгийн алдааг санхүүгийн тайланд залруулсан байна. Төсвийн шууд захирагчдад өгсөн зөвлөмжийн 11 нь бүртгэл, тайлагналтай холбоотой, 48 нь хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой, 2 нь төлөвлөлт, хяналт, дотоод аудитын чанар, үр нөлөөг сайжруулахтай холбоотой байна.

Дотоод аюулгүй байдлын хэлтсийн дотоод аудитор 2016 оны 6 сард ажлаасаа чөлөөлөгдөж, тухайн орон тоон дээр өнөөг хүртэл ажилтан томилогдоогүй, УЕП-ын системийн хэмжээнд 41 байгууллага нэгтгэгдэг боловч Нийслэлийн Налайх дүүргийн прокурорын газрын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудитын шалгалт хийсэн нь хангалтгүй байна.

ТШЗ-ийн хэмжээнд 2016 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн асуудлуудыг аудитын тайланд хураангуйлан тэмдэглэсэн бөгөөд УЕП-ын удирдлагын анхааралд хандуулсан асуудлууд нь 2015 оны ТЭЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаар мөн адил хөндөгдсөн тул давтан гаргахгүй байх ажлыг зохион байгуулж ажиллахыг тус байгууллагын удирдлага болон Дотоод аюулгүй байдлын хэлтэст зөвлөж байна.

Энэ нь Дотоод аудитын дүрмийн 2 дугаар зүйлийн 2.1-д "Төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод аудитын үйл ажиллагаа нь хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангах чиглэлээр тухайн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад дэмжлэг үзүүлэхэд оршино", мөн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.1-д "Дотоод аудитын нэгж нь Төрийн аудитын байгууллагатай дараах хүрээнд хамтран ажиллаж болно 9.1.1-9.1.3 дахь заалт" гэснийг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: ТШЗ-дын аудитаар илэрсэн асуудлуудад анхаарал хандуулан ажиллах, дотоод аудитыг яаралтай томилж, дотоод хяналт, шалгалтын ажлын үр дүнг сайжруулах талаар УЕП-ын удирдлагад зөвлөмж болгох;

1.10 АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Дараагийн аудитаар УЕП-ын системийн хэмжээнд цалин хөлс болон нэмэгдэл, урамшуулал, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэл, суутгалууд, цалингийн бодолт болон холбогдох эрх зүйн актыг судлан шалгавал зохилтой байна.

1.11 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АСУУДЛУУД

Монгол Улсын Ерөнхий прокурорын төсвийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын явцад гүйцээж, мөшгин шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй болно.

1.12 АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

Монгол Улсын Ерөнхий прокурорын төсвийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар дээрх зөрчлийг давтан гаргахгүй байх талаар Улсын ерөнхий прокурорын газрын удирдлагуудын анхааралд хандуулж 3 зөвлөмж өглөө.

1.13 ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Монгол Улсын Ерөнхий прокурорын төсвийн 2015 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд Үндэсний аудитын газраас аудит хийж 1 албан шаардлага, 3 зөвлөмж өгснийг 85 хувьтай хэрэгжүүлсэн байна.

Албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг 2016 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн 2/2653, 2016 оны 7 дугаар сарын 5-ны өдрийн 2/2876, 2017 оны 1 дүгээр сарын 23-ны өдрийн 2/342 дугаар албан бичгээр Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна.

1.14 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР:

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагыг сонгов.

Төсвөөс санхүүждэг төрийн өмчит төсөвт байгууллага тул төлөвлөлтөөр материаллаг байдлын суурийг 2016 оны санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлангийн нийт зардлаар авч, түүний 2 хувиар тооцож, /20,018.4х 2%/ 400.4 сая төгрөгөөр материаллаг байдлыг тогтоосон. Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын суурийг дахин тооцоогүй бөгөөд материаллаг байдлын түвшинд өөрчлөлт ороогүй болно.

1.15 САНАЛ ДҮГНЭЛТИЙН ХЭЛБЭР, ҮНДЭСЛЭЛ

Бид Монгол Улсын Ерөнхий прокурорын төсвийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг баталгаажуулах ажлыг Аудитын олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Монгол Улсын Ерөнхий прокурорын төсвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна гэж үзэж, “Зөрчилгүй” санал дүгнэлт өгөхийг Монгол Улсын Ерөнхий аудитор санал болгож байна.

Аудитын явцад илэрсэн зөрчлийн талаарх үнэлэлт дүгнэлтийг энэ тайлангийн 2.12-д тусгасан бөгөөд залруулаагүй алдаа, зөрчлийг материаллаг байдлын түвшинтэй харьцуулахад аудитын санал дүгнэлтийг хязгаарлах үндэслэлгүй байна.

Аудитын санал дүгнэлтийг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

2 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Үндэсний аудитын газар аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүүгийн хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан.

Энэ нь Монгол Улсын Ерөнхий прокурорын төсвийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан санхүүгийн ажилтнууд болон Дотоод аудитын албаны холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн нэгтгэсэн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг ач холбогдлынх нь дарааллаар эрэмбэлэн дор нэгтгэн харуулав.

2.1 Үндсэн хөрөнгийн талаар

Тэргүүлэх ач холбогдол №1

ҮАГ-ын ажиглалт

Тайлант онд түүвэрт хамрагдсан Эрүүгийн хэргийн төв архивын газарт ашиглагдаж байгаа нийт 5.0 сая төгрөгийн анхны өртөгтэй 1.2 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй 4 нэр төрлийн тавилга эд хогшил нь УЕП-ын Тамгын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 3-т “Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр хандивлах, бэлэглэх, барьцаалах, зээлдүүлэх, бусад өмчийн хуулийн этгээдэд хувь хөрөнгө болгон оруулахыг хориглоно”, Иж бүрэн байх батламж мэдэгдлийн “Аж ахуйн нэгж, байгууллага тайлант хугацаанд гарсан бүх ажил гүйлгээ, үлдэгдэл буюу үйл явдал, нөхцөл байдлуудаас бүртгээгүй, нэмж тодруулаагүй, орхигдуулсан зүйлсгүй байх” гэсэнтэй тус бүр нийцэхгүй байна.

ҮАГ-ын зөвлөмж

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн заалтыг баримталж, эрх бүхий байгууллагын холбогдох шийдвэрээр хөрөнгийн хөдөлгөөнийг хийж, бүртгэлд тусгаж байх;

Зөвлөмжийн биелэлтийг 2017 оны 12 сарын 01-ны дотор өгөх;

Эрсдэлүүд

-Ажил гүйлгээ данс бүртгэлд тусгагдаагүй байх;
-Холбогдох стандарт, хууль, тогтоол, журам, заавар зөрчсөн байх;

Төсвийн захирагчийн хариу

Зөвлөмжийг хүлээн авч хэрэгжүүлнэ.

2.2 Цалин орон тооны талаар

Тэргүүлэх ач холбогдол №1

ҮАГ-ын ажиглалт

Төсвийн шууд захирагчдын 2016 оны санхүүгийн тайлангийн аудитаар гарсан нийтлэг алдааг УЕП-ын газрын удирдлагуудад хандуулбал дараах байдалтай байна.

- УЕП-ын харьяа Прокурорын газрууд нь нийт 175.5 сая төгрөгийн ажил гүйлгээг урьдчилгаа-цалингийн тооцооны дансаар дамжуулан бүртгээгүйгээс аудитаар ажиллагсадтай холбоотой авлага, өглөгийн тооцоо үүссэн;
- УЕП-ын газрын даргын тушаалаар төрийн үйлчилгээний албан хаагчдын албан тушаалын ангилал, зэрэглэлийг буруу тогтоосноос нийт 35.4 сая төгрөгийг тайлант онд илүү олгосон;

УЕП-ын газраас авсан орон тоо, цалин, НДШ-ийн зардлын судалгаанаас үзэхэд 2016 оны Төсвийн тухай хуулиар баталсан цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл бүлгийн дүнгээр батлагдсан төсвөөс хэтрээгүй боловч батлагдсан орон тооны хязгаарыг хэтрүүлэн нийт 33 гэрээт ажилтанг ажиллуулж, цалин хөлс олгож, холбогдох зардлуудыг төлсөн байна.

Энэ нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан дансны заавар, Засгийн газрын 2007 оны “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан тушаалын ангилал, зэрэглэлийг шинэчлэн тогтоох тухай” 354 дүгээр тогтоол, 2014 оны “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, доод жишгийг шинэчлэн тогтоох тухай” 332 дугаар тогтоол, 2016 оны төсвийн тухай хуультай тус бүр нийцэхгүй байна.

Эрсдэлүүд

-Зориулалт бусаар зарцуулсан байх;
-Холбогдох стандарт, хууль, тогтоол, журам, заавар зөрчсөн байх;

ҮАГ-ын зөвлөмж

Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар", Засгийн газрын 2007 оны 354, 2014 оны 332 дугаар тогтоолтой нийцүүлэн ажиллагсдын цалин хөлсийг зөв тогтоож, тооцоолон санхүүгийн тайланд үнэн зөв тайлагнаж байх, батлагдсан орон тооны хязгаарт багтаан ажиллаж, урсгал төсвийг хэмнэх;

Зөвлөмжийн биелэлтийг 2017 оны 12 сарын 01-ны дотор өгөх;

Төсвийн захирагчийн хариу

Зөвлөмжийг хүлээн авч хэрэгжүүлнэ.

2.3 Дотоод хяналтын талаар

Тэргүүлэх ач холбогдол №1

ҮАГ-ын ажиглалт

Төсвийн шууд захирагчдын 2015 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 1,983.3 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрч байсан бол тайлант онд нийт 1,123.8 сая төгрөгийн алдаа зөрчил илэрч 0.4 сая төгрөгийн зөрчилд 1 акт тогтоож, 257.7 сая төгрөгийн зөрчилд 61 зөвлөмж өгч, 862.0 сая төгрөгийн алдааг залруулсан байна. Төсвийн шууд захирагчдад өгсөн зөвлөмжийн 11 нь бүртгэл, тайлагналтай холбоотой, 48 нь хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой, 2 нь төлөвлөлт, хяналт, дотоод аудитын чанар, үр нөлөөг сайжруулахтай холбоотой байна.

Дотоод аюулгүй байдлын хэлтсийн дотоод аудитор 2016 оны 6 сард ажлаасаа чөлөөлөгдөж, тухайн орон тоон дээр өнөөг хүртэл ажилтан томилогдоогүй, УЕП-ын системийн хэмжээнд 41 байгууллага нэгтгэгдэг боловч Нийслэлийн Налайх дүүргийн Прокурорын газрын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудитын шалгалт хийсэн нь хангалтгүй байна.

ТШЗ-ийн хэмжээнд 2016 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн асуудлуудыг аудитын тайланд хураангуйлан тэмдэглэсэн бөгөөд УЕП-ын удирдлагын анхааралд хандуулсан асуудлууд нь 2015 оны ТЭЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаар мөн адил хөндөгдсөн тул давтан гаргахгүй байх ажлыг зохион байгуулж ажиллахыг тус байгууллагын удирдлага болон Дотоод аюулгүй байдлын хэлтэст зөвлөж байна.

Энэ нь Дотоод аудитын дүрмийн 2 дугаар зүйлийн 2.1, 9 дүгээр зүйлийн 9.1.1-9.1.3 дахь заалтуудыг хэрэгжүүлээгүй байна.

Эрсдэлүүд

- Дансны бичилт буруу хийгдсэн байх;
- Холбогдох стандарт, хууль, тогтоол, журам, заавар зөрчсөн байх;
- Дотоод аудитын дүрмийг хэрэгжүүлэх;

ҮАГ-ын зөвлөмж

ТШЗ-дын аудитаар илэрсэн асуудлуудад анхаарал хандуулан ажиллах, дотоод аудиторыг яаралтай томилж, дотоод хяналт, шалгалтын ажлын үр дүнг сайжруулах;

Зөвлөмжийн биелэлтийг 2017 оны 12 сарын 01-ны дотор өгөх;

Төсвийн захирагчийн хариу

Зөвлөмжийг хүлээн авч хэрэгжүүлнэ.

3 Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

3.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мян.төг)			
Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2015 оны 12-р сарын 31	2016 оны 12-р сарын 31
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		1,067,243.3	684,350.9
МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	589,115.4	254,259.8
АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	43,561.4	31,259.9
УРЬДЧИЛГАА	7а, 7б	5,161.4	1,000.0
БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	425,437.9	397,831.3
НӨӨЦИЙН БАРАА	9а	3,967.3	0.0
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		21,162,006.8	19,387,802.2
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	21,162,006.8	19,387,802.2
Биет хөрөнгө		21,109,398.8	19,372,850.4
Биет бус хөрөнгө	13	52,608.0	14,951.8
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		22,229,250.0	20,072,153.1
НИЙТ ӨР ТӨЛБӨР		2,035,905.2	476,152.9
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15а, 15б	2,035,905.2	476,152.9
Өглөг	17а, 17б	2,035,905.2	309,135.1
Урьдчилж орсон орлого	18а, 18б	0.0	167,017.8
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		20,193,344.9	19,596,000.3
Засгийн газрын хувь оролцоо		12,625,705.8	12,625,705.8
Хуримтлагдсан үр дүн		5,608,864.0	5,076,803.8
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		1,958,775.0	1,893,490.6
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		22,229,250.0	20,072,153.1

3.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мян.төг)			
Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2015 оны 12-р сарын 31	2016 оны 12-р сарын 31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)		23,480,389.2	17,930,934.2
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	4,565,683.2	110,453.1
Нийтлэг татварын бус орлого		4,565,683.2	110,453.1
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		18,914,706.0	17,820,481.1
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	22,370,243.9	19,856,146.8
УРСГАЛ ЗАРДАЛ		21,039,443.9	19,856,146.8
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		18,210,729.9	19,564,202.4
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		12,752,595.9	12,544,035.7
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		1,403,296.4	1,395,617.2
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		774,006.7	840,541.5
Хангамж, бараа материалын зардал		932,323.7	2,324,713.4
Нормативт зардал		38,702.1	21,388.6
Эд хогшил, урсгал засварын зардал		190,454.6	281,177.4
Томилолт, зочны зардал		159,820.6	87,849.8
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		48,964.6	54,506.7
Бараа үйлчилгээний бусад зардал		1,910,565.3	2,014,372.1
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		2,828,714.1	291,944.5
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		1,330,800.0	-
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		1,110,145.3	(1,925,212.7)
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		4,241,850.4	162,273.8
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)		(3,131,705.1)	(2,087,486.5)

3.3 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мян.төг)

Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө /өмч
2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	20,061,106.7	-	20,061,106.7
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	3,270,623.9	-	3,270,623.9
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	23,331,730.6	-	23,331,730.6
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(6,680.6)	-	(6,680.6)
Тайлант үеийн үр дүн	(3,131,705.1)	-	(3,131,705.1)
2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	20,193,344.9	-	20,193,344.9
2016 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	20,193,344.9	-	20,193,344.9
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	1,493,259.4	-	1,493,259.4
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	21,686,604.3	-	21,686,604.3
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(3,117.5)	-	(3,117.5)
Тайлант үеийн үр дүн	(2,087,486.5)	-	(2,087,486.5)
2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	19,596,000.3	-	19,596,000.3

3.4 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мян.төг)		
ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ	2015 оны 12-р сарын 31	2016 оны 12-р сарын 31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	22,391,993.1	18,002,979.1
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,413,144.9	152,285.5
Нийтлэг татварын бус орлого	3,413,144.9	152,285.5
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	18,978,848.2	17,850,693.6
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	21,198,950.3	16,792,854.7
УРСГАЛ ЗАРДАЛ	21,198,950.3	16,792,854.7
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	16,506,580.8	16,054,212.1
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	12,780,289.4	12,557,968.5
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,418,401.0	1,381,013.2
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	781,955.3	829,620.9
Хангамж, бараа материалын зардал	776,963.2	721,887.1
Нормативт зардал	24,270.1	14,487.6
Эд хогшил, урсгал засварын зардал	206,414.5	212,276.2
Томилолт, зочны зардал	142,892.7	70,705.9
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	54,433.8	72,037.6
Бараа үйлчилгээний бусад зардал	320,960.9	194,215.3
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,692,369.4	738,642.7
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	1,193,042.9	1,210,124.4
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	1,846,977.9	1,545,862.3
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,846,977.9	1,545,862.3
Дотоод эх үүсвэрээр	1,846,977.9	1,545,862.3
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(1,846,977.9)	(1,545,862.3)
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-	882.3
Бусад эх үүсвэр	-	882.3
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	(653,935.0)	(334,855.6)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,243,050.4	589,115.4
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	589,115.4	254,259.8

3.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мян.төг)				
Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	17,660,244.2	17,656,001.8	4,242.4	100.0
УРСГАЛ ЗАРДАЛ	16,171,944.2	16,167,841.7	4,102.5	100.0
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	15,948,242.1	15,944,139.9	4,102.2	100.0
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	12,566,668.5	12,557,968.5	8,700.0	99.9
Үндсэн цалин	12,003,066.2	12,079,305.2	(76,239.0)	100.6
Унаа хоолны хөнгөлөлт	385,271.1	357,819.1	27,452.0	92.9
Гэрээт ажлын хөлс	178,331.2	120,844.2	57,487.0	67.8
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,380,291.7	1,381,013.2	(721.5)	100.1
Тэтгэврийн даатгал	881,098.4	1,098,414.0	(217,315.6)	124.7
Тэтгэмжийн даатгал	89,620.3	51,954.1	37,666.2	58.0
ҮОМШӨ-ний даатгал	121,405.4	69,445.7	51,959.7	57.2
Ажилгүйдлийн даатгал	31,659.1	18,864.4	12,794.7	59.6
Эрүүл мэндийн даатгал	256,508.5	142,334.9	114,173.6	55.5
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	824,778.6	824,482.8	295.8	100.0
Гэрэл, цахилгаан	135,524.2	152,529.9	(17,005.7)	112.6
Түлш, халаалт	543,238.0	532,723.0	10,515.0	98.1
Цэвэр, бохир ус	65,149.2	58,542.8	6,606.4	89.9
Байрны түрээс	80,867.2	80,687.1	180.1	99.8
Хангамж, бараа материалын зардал	713,792.2	715,045.1	(1,252.9)	100.2
Бичиг хэрэг	135,661.6	139,122.3	(3,460.7)	102.6
Тээвэр, шатахуун	197,415.0	196,594.9	820.1	99.6
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	310,275.9	299,830.0	10,445.9	96.6
Ном, хэвлэл	3,412.2	3,789.1	(376.9)	111.0
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,275.7	2,349.2	(73.5)	103.2
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	64,751.8	73,359.7	(8,607.9)	113.3
Нормативт зардал	13,737.1	14,280.4	(543.3)	104.0
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	500.0	(500.0)	-
Нормын хувцас, зөөлөн эдлэл	13,737.1	13,780.4	(43.3)	100.3
Эд хогшил, урсгал засварын зардал	183,964.3	185,387.6	(1,423.3)	100.8
Багаж, техник, хэрэгсэл	4,878.0	5,208.0	(330.0)	106.8
Урсгал засвар	179,086.3	180,179.6	(1,093.3)	100.6
Томилолт, зочны зардал	70,976.5	70,705.9	270.6	99.6
Гадаад албан томилолт	7,767.4	7,767.5	(0.1)	100.0
Дотоод албан томилолт	61,056.6	60,786.0	270.6	99.6
Зочин төлөөлөгч хүлээн авах	2,152.5	2,152.4	0.1	100.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	63,841.6	63,877.4	(35.8)	100.1
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	87.5	120.5	(33.0)	137.7
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,315.0	2,591.0	(276.0)	111.9
Даатгалын үйлчилгээ	31,438.0	31,438.0	-	100.0
Тээврийн хэрэгслийн татвар	9,122.0	8,880.4	241.6	97.4
Тээврийн хэрэгслийн оношлогоо	624.6	564.6	60.0	90.4
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	17,591.7	17,591.7	-	100.0
Газрын төлбөр	2,662.8	2,691.2	(28.4)	101.1
Бараа үйлчилгээний бусад зардал	130,191.6	131,379.1	(1,187.5)	100.9

Монгол Улсын Ерөнхий прокурорын төсвийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

Бараа үйлчилгээний бусад зардал	63,128.7	63,099.4	29.3	100.0
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	67,062.9	68,279.6	(1,216.7)	101.8
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	223,702.1	223,701.8	0.3	100.0
Бусад урсгал шилжүүлэг	223,702.1	223,701.8	0.3	100.0
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	194,023.6	194,023.4	0.2	100.0
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	29,678.5	29,678.5	0.0	100.0
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,488,300.0	1,488,160.0	140.0	100.0
Барилга байгууламж	1,329,300.0	1,488,160.0	(158,860.0)	112.0
Тоног төхөөрөмж	159,000.0	-	159,000.0	100.0
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	17,660,244.2	17,656,268.5	3,975.7	100.0
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	17,660,244.2	17,652,387.0	7,857.2	100.0
Улсын төсвөөс санхүүжих	17,660,244.2	17,652,387.0	7,857.2	100.0
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	-	3,881.5	(3,881.5)	-
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	3,881.5	(3,881.5)	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	2,022.0	(2,022.0)	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	266.7	(266.7)	-
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	2,009.0	2,075.0	(66.0)	103.3
БАЙГУУЛЛАГЫН ТОО	41.0	41.0	-	100.0
Төсвийн байгууллага	41.0	41.0	-	100.0
АЖИЛЛАГСДЫН ТОО	984.0	1,017.0	(33.0)	103.4
Удирдах ажилтан	52.0	52.0	-	100.0
Гүйцэтгэх ажилтан	487.0	679.0	(192.0)	139.4
Үйлчлэх ажилтан	445.0	253.0	192.0	56.9
Гэрээт ажилтан	-	33.0	(33.0)	-
ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	984.0	1,017.0	(33.0)	103.4
Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	-	-	-	-
Төрийн тусгай албан хаагч (ТТ)	504.0	504.0	-	100.0
Ажлын албаны албан хаагч (АА)	179.0	179.0	-	100.0
Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	301.0	301.0	-	100.0
Гэрээт ажилтан	-	33.0	(33.0)	-